

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2021-09-14

Тендерийн дугаар: МРЦМ/202105614

“Монголпросцветмет” ТӨҮГ нь эрх бүхий тендерт оролцогчдыг **“Байгаль орчин, нөхөн сэргээлт”** нэртэй техникийн нөхөн сэргээлт хийх үйлчилгээ үзүүлэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 50.000 төгрөгөөр www.tender.gov.mn цахим системээс худалдан авах боломжтой. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 оны аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.

Сүүлийн 2 жилд ижил төстэй ажил гүйцэтгэж байсан туршлагатай байна.

Тендерийн хамт 6,500,000 төгрөгийн тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг **2021 оны 09 дүгээр сарын 20-ны** өдрийн 09:00 цагаас өмнө **Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем** www.tender.gov.mn хаягаар ирүүлэх бөгөөд **2021 оны 09 дүгээр сарын 20-ны** өдрийн 09:05 цагт цахимаар нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем
www.tender.gov.mn